



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/79/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	“Эс Жи Эм Ди-Аудит” ХХК	
	Захирал:	Д.Эхбаяр
	Утас: 70006948	Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
	Аудитын менежер:	Д.Насанжаргал
	Утас: 70006948	Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn
	Ахлах Аудитор:	О.Алтанцэцэг
Утас: 70006948	Цахим хаяг: info@sgmd-audit.mn	
Аудитын шинжээч:	Ч.Ням-Очир	
Утас: 70006948	Цахим хаяг: c.nyamaa@sgmd-audit.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Ауд. 03.15 № 537

танай _____-ны № _____-т

БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.МӨНХНАСАН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 64 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон****/төгрөгөөр/**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	177,024,386.95	109,358,497.05
1.1.2	Дансны авлага	35,431,052.44	46,782,259.56
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,270,749.62	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	17,717,280.00
1.1.6	Бараа материал	128,140,101.64	180,061,225.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	341,866,290.65	353,919,262.34
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,214,130,939.45	1,236,637,512.39
1.2.2	Биет бус хөрөнгө	46,193,333.33	57,527,224.45
1.2.8	Биологийн хөрөнгө	13,125,481.76	10,610,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,273,449,754.64	1,304,774,736.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,615,316,045.29	1,658,693,999.18
2.1.1.1	Дансны өглөг	51,570,514.79	138,961,994.24
2.1.1.3	Татварын өр	310,784,222.97	165,614,877.07
2.1.1.4	НДШ - ийн өглөг	25,200.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	362,379,937.76	304,576,871.31
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	362,379,937.76	304,576,871.31
2.3	Эздийн өмч	1,273,510,999.39	1,273,510,999.39
2.3.1	төрийн	1,273,510,999.39	1,273,510,999.39
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	31,457,407.97	31,457,407.97
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	46,110,000.00	46,110,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(98,142,299.83)	3,038,720.51
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,252,936,107.53	1,354,117,127.87
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,615,316,045.29	1,658,693,999.18

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,475,844,838.98	5,278,899,944.95
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,000,773,750.27	4,609,424,935.83
3	Нийт ашиг (алдагдал)	475,071,088.71	669,475,009.12
8	Бусад орлого	175,000.00	2,625,155.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	419,918,332.36	559,676,808.29
12	Бусад зардал	38,516,617.94	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(18,778,936.86)	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,967,798.45)	112,423,355.93
19	Орлогын татварын зардал	0.00	11,242,335.59
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(1,967,798.45)	101,181,020.34
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,967,798.45)	101,181,020.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(1,967,798.45)	101,181,020.34
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(96,174,501.38)	1,254,903,905.98
3	Залруулсан үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(96,174,501.38)	1,254,903,905.98
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,967,798.45)	(1,967,798.45)
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(98,142,299.83)	1,252,936,107.53
11	Залруулсан үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(98,142,299.83)	1,252,936,107.53
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				101,181,020.34	101,181,020.34
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	3,038,720.51	1,354,117,127.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн	4,933,088,246.01	5,802,746,353.04
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,927,665,310.00	5,794,077,031.19
1.1.6	Бусад мөнгөн орлого	5,422,936.01	8,669,321.85
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,763,403,485.92	5,765,127,442.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	161,736,034.50	237,089,105.13
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,703,200.70	69,354,339.11
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,287,313,037.69	4,801,009,776.13
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	53,662,919.48	58,198,979.46
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	23,202,788.93	59,364,636.37
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	96,507,107.28	461,224,523.01
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	247,185.00	114,750.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	75,031,212.34	78,771,333.73
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	169,684,760.09	37,618,910.10
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	105,284,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	90,681,200.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	14,603,600.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(105,284,800.00)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	25,686,232.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	25,686,232.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,686,232.00)	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	143,998,528.09	(67,665,889.90)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,025,858.86	177,024,386.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	177,024,386.95	109,358,497.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны зорилтот түвшний		Зөрүү	Хувиар
				төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	мян.төг	4,475,264.80	7,939,370.30	5,278,899.90	2,660,470.40	66.5
2	Бусад орлого	мян.төг	755.00	500.00	2,625.20	(2,125.20)	525.0
3	<u>Нийт орлого</u>	мян.төг	<u>4,476,019.80</u>	<u>7,939,870.30</u>	<u>5,281,525.10</u>	2,658,345.20	66.5
4	ББӨ	мян.төг	4,000,773.70	7,012,492.20	4,609,424.90	2,403,067.30	65.7
5	Цалингийн зардал	мян.төг	206,559.50	452,987.30	307,454.00	145,533.30	67.9
6	НДШ-ийн зардал	мян.төг	25,213.40	56,623.40	39,111.50	17,511.90	69.1
7	Шуудан холбооны зардал	мян.төг	1,015.60	2,220.00	1,625.20	594.80	73.2
8	Гэрэл цахилгааны зардал	мян.төг	45,187.60	63,816.00	49,199.30	14,616.70	77.1
9	Шатахууны зардал	мян.төг	13,734.10	20,420.00	13,790.30	6,629.70	67.5
10	Албан томилолтын зардал	мян.төг	0.00	9,000.00	0.00	9,000.00	0.0
11	Бичиг хэргийн зардал	мян.төг	5,022.40	6,721.00	6,202.30	518.70	92.3
12	Ашиглалтын зардал	мян.төг	8,475.40	10,500.00	9,575.40	924.60	91.2
13	Сэлбэг хэрэгслийн зардал	мян.төг	6,358.40	8,390.00	7,545.40	844.60	89.9
14	Тээврийн зардал	мян.төг	962.50	2,200.00		2,200.00	0.0
15	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	5,564.90	11,704.00	6,428.20	5,275.80	54.9
16	Татварын зардал	мян.төг	1,300.40	1,829.00	1,271.90	557.10	69.5
17	Засвар үйлчилгээний зардал	мян.төг	7,024.30	63,000.00	6,898.80	56,101.20	11.0
18	Бусад зардал	мян.төг	25,690.60	18,665.00	21,458.70	(2,793.70)	115.0
19	Шагнал урамшууллын зардал	мян.төг	0.00	7,000.00	1,000.00	6,000.00	14.3
20	Сургалтын зардал	мян.төг	455.00	7,800.00	445.00	7,355.00	5.7
21	Элэгдлийн зардал	мян.төг	67,264.40	74,500.00	64,468.50	10,031.50	86.5
22	Бараа материал акталсны зардал	мян.төг	33,697.20	0.00	0.00	0.00	#DIV/0!
23	<u>ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>4,454,389.30</u>	<u>7,829,867.90</u>	<u>5,145,899.40</u>	<u>2,683,968.50</u>	65.7
22	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	23,598.30	24,550.00	23,202.20	1,347.80	94.5
23	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>23,598.30</u>	<u>24,550.00</u>	<u>23,202.20</u>	<u>1,347.80</u>	94.5
24	<u>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>4,477,987.60</u>	<u>7,854,417.90</u>	<u>5,169,101.60</u>	<u>2,685,316.30</u>	65.8
26	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян.төг	(1,967.80)	85,452.40	112,423.50	(26,971.10)	131.6
27	Орлогын татвар	мян.төг		8,545.24	11,242.35	(2,697.11)	131.6
28	Цэвэр ашиг	мян.төг	(1,967.80)	76,907.16	101,181.15	(24,273.99)	131.6
29	Хөрөнгө оруулалт	мян.төг		123,000.00	106,500.00	16,500.00	86.6
30	<u>Ажилчдын тоо</u>	-	-	26	18	8	

Гурав. Аудитын илрүүлэлт:

1. Аудитаар нийт 13,125.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

Санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлийг 13,125.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн нь НББОУС1-ийн 27 зүйл: "...үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНБОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг..." заалт, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 17,538.8 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 1,861.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 15,677.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

2. Төлбөрийн акт

1.Тус байгууллагын захиралд 8 дугаар сард ээлжийн амралттай байх хугацаанд цалин бодож 1,861.5 мянган төгрөг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Амралтын мөнгө, цалинг давхардуулж олгосон зөрчлийг арилгах, төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант хугацаанд кассаас байгууллагын ажилчдын үзвэрийн билетийн төлбөрт 640.0 мянга, заалны түрээсийн төлбөрт 266.7 мянга, нийт 906.7 мянган төгрөгийг зарцуулж бусад зардлаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх," 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоолоо.

3. Албан шаардлага

1.Тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс дутагдал гарч ажилчид, хувь хүмүүсээс авах авлагаар тайлагнасан, бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээнд нийлүүлэх бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийг тодорхой тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10/ "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах," 11/ "хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийн арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант хугацаанд 8 тендерт шалгарсан нэр бүхий 5 компаниас 148,011.8 мянган төгрөгийн тендерийн гүйцэтгэлийн баталгаа аваагүй, тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана;”, 43.4.2 “100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;”, 46 дугаар зүйлийн 46.1.2-т “үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;” заалтууд, Сангийн сайдын 2021.06.30-ны өдрийн 103 дугаар тушаалын 3.2-т “Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан эрх эдэлж үүрэг хүлээх ба худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. “Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулиудад хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерийг 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зарлаж 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр нээсэн, тендерийн үнэлгээг 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр хийж, гэрээг 2023 оны 5 дугаар сарын 9-ны өдөр байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.”, 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.”, 46 дугаар зүйлийн 46.1.2-т “үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах;” 47 дугаар зүйлийн 47.8 “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.” заалтууд, Сангийн сайдын 2021.06.30-ны өдрийн 103 дугаар тушаалын 3.2-т “Үнэлгээний хороонд томилогдсон гишүүн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан эрх эдэлж үүрэг хүлээх ба худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийг үнэлгээг хуулийн хугацаанд хийгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. “Грийн дистрибьюшн” ХХК-тай хүнсний бараа худалдах, худалдан авах гэрээ байгуулж 307,114.8 мянган төгрөгийн бараа худалдаж авсны 299,449.5 мянган төгрөгийг охин компани болох “Грийн импекс” ХХК-руу шилжүүлж, төлбөрийн и-баримт нь “Грийн” ХХК-аас шивэгдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;”, 10/ “эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;”, 11 “хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасан эрх үүрэг, гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Зөвлөмж

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22 нэр төрлийн (15,677.3 мянган төгрөг) үндсэн хөрөнгө байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртөгтөө нөхсөн хөрөнгүүдийг холбогдох дээд байгууллагаас шийдвэр гаргуулан үнийг шинэчлэн тогтоох;

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Байгууллагын ажилчдын цалинг захирлын 2023 оны А/01 тоот тушаал болон А/13 тоот тушаалаар тогтоосон бөгөөд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон нийтлэг жишгийг үндэслэл болгоогүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтоож байх зөвлөмж өгсөн.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт-3: Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах цэнхэр дэвсгэртэй дугаараар солиогүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах мод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгслийг цэнхэр дэвсгэртэй улсын дугаартай болгох зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багачууд хүнс ОНӨААТҮГ	1	13.1			1	13.1	1	13.1				
Дүн	1	13.1			1	13.1	1	13.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Багачууд хүнс ОНӨААТҮГ	3	17.5	1	1.8	1	0.0	1	15.7	-	-	-	-
Дүн	3	17.5	1	1.8	1	0.0	1	15.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										

Багачууд хүнс ОНӨААТҮГ	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Багачууд хүнс ОНӨААТҮГ	6	448,368.0	1	906.7	3	447,461.3	2	0.0
Дүн	6	448,368.0	1	906.7	3	447,461.3	2	0.0
Нийт дүн	7	448,368.0	2	906.7	3	447,461.3	3	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Багачууд хүнс ОНӨААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			